

**ТӨСВИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**
2024 оны 11 дүгээр сарын 08-ны өдөр, Баасан гараг

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	0
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	1-2
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	3-8

1. “Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл	3-8
--	-----

**Монгол Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганы
Төсвийн байнгын хорооны 11 дүгээр сарын 08-ны өдөр
/Баасан гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Төсвийн байнгын хорооны дарга Ц.Даваасүрэн ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 25 гишүүнээс 13 гишүүн хүрэлцэн ирж, 52.0 хувийн ирцтэйгээр хуралдаан 09 цаг 45 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Томилолттой: Б.Заяабал;

Чөлөөтэй: Н.Алтанхуяг, Д.Батбаяр, Р.Батболд, З.Мэндсайхан, Д.Пүрэвдаваа, Г.Тэмүүлэн, Да.Цогтбаатар, Б.Чойжилсүрэн;

Эмнэлгийн чөлөөтэй: Х.Болормаа, Б.Түвшин.

Нэг. “Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Баасандорж, Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, мөн газрын Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх А.Болортуяа, Ё.Энхсайхан, Байнгын хороодын ажлын албаны Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, мөн албаны Төсвийн байнгын хорооны ажлын албаны референт Б.Мөнгөн-Аргамж, Хяналт шалгалтын газрын Төсвийн хяналт, шинжилгээний хэлтсийн референт Д.Гэрэлт-Од, С.Төрмөнх нар байлцав.

Байнгын хорооны дарга Ц.Даваасүрэн тогтоолын төслийн талаар танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал, Х.Ганхуяг, Г.Дамдинням, Г.Ганбаатар, Т.Аубакир нарын тавьсан асуултад Байнгын хорооны дарга Ц.Даваасүрэн хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүдээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Ц.Даваасүрэн: 1.Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргалын гаргасан, Тогтоолын төслийн 2 дахь дэд заалтыг бүхэлд нь хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 2
Татгалзсан: 13
Бүгд: 14
14.3 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Дээрх саналтай холбогдуулан Сангийн сайд Б.Жавхлан үг хэлэв.

2.Улсын Их Хурлын гишүүн Г.Дамдиннямын гаргасан, Төслийн 2 дахь дэд заалтын “2025 оны 01 дүгээр улиралд” гэснийг “2024 оны 12 дугаар сард” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 5
Бүгд: 14
64.3 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргалын гаргасан, Төслийн 1 дэх дэд заалтын “баримтлахад нөлөөлөх” гэснийг “тогтвортой хангахад нөлөөлж буй хүчин зүйлүүдийн” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 5
Татгалзсан: 9
Бүгд: 14
35.7 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Байнгын хорооны дарга Ц.Даваасүрэн “Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг эцэслэн батлах үе шаттай нэгтгэн явуулах горимын саналыг нэгдсэн хуралдаанд гаргах нь зүйтэй гэсэн горимын санал гаргав.

Ц.Даваасүрэн: Горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 5
Бүгд: 14
64.3 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Т.Аубакир, Г.Дамдинням, Д.Батлут нарын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дэмжсэнээр тооцож, 85.7 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Г.Дамдинням Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 10 цаг 25 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 41 минут үргэлжилж, 25 гишүүнээс 14 гишүүн хүрэлцэн ирж, 56.0 хувийн ирцтэйгээр 10 цаг 26 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ТӨСВИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Ц.ДАВААСҮРЭН

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААН ЗОХИОН
БАЙГУУЛАХ ХЭЛТСИЙН
ШИНЖЭЭЧ

Э.СУВД-ЭРДЭНЭ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ
2024 оны 11 дүгээр сарын 08-ны өдөр,
Баасан гараг Төрийн ордон
“Жанжин Д.Сүхбаатар” танхим,
09 цаг 45 минут

**ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ
ТЭМДЭГЛЭЛ**

Ц.Даваасүрэн: Ирц бүрдсэн учраас хэдүүлээ хуралдаанаа эхэлье. Бүртгүүлсэн гишүүд орж ирье. 25-13 гишүүн ирж, хуралдааны ирц 52 хувьтай байна. Хуралдааны ирц бүрдсэн байна. Бүртгүүлсэн гишүүд орж ирье. Ирсэн гишүүдийг танилцуулъя.

Ц.Даваасүрэн, Т.Аубакир,
Ж.Батжаргал, Д.Батлут, Б.Батцэцэг,
Ж.Баясгалан, Х.Булгантуяа,
Г.Ганбаатар, Б.Ганзориг, Ж.Ганбаатар,
Х.Ганхуяг, Г.Дамдинням, Б.Мөнхсоёл,
П.Мөнхтулга. Сая 1 гишүүн бүртгүүлсэн дээ хэн бүртгэв. Эдгээр гишүүд ирж бүртгүүлсэн байна. Ингээд хуралдаанаа эхэлье. Хуралдааны ирц 56 хувьтай байгаа учраас хуралдааныг эхлүүлъя.

Өнөөдрийн хуралдаанаар 1 асуудал хэлэлцэнэ.

“Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлэг.

Хэлэлцэх асуудалтай холбогдолтойгоор саналтай гишүүн байна уу. Алга байна. Хэлэлцэх асуудлаа баталъя. Хэлэлцэх асуудлын төслийг та бүхэнд тараасан байгаа.

Тогтоолын төсөлтэй холбогдуулаад асуулт асууж, үг хэлэх гишүүн байна уу. Ганхуяг гишүүнээр тасалъя. Батжаргал гишүүн.

Ж.Батжаргал: Тэгэхээр улсын төсөв баталж байгаа бүрэн эрх нь Улсын Их Хуралд өөрт нь байгаа юм. Тэгээд төсөв батлагдсантай холбогдуулж авч хэрэгжүүлэх арга хэмжээний тогтоол батлахаар бид хэд Байнгын хорооноос санаачлаад үндсэндээ орж ирж байна. Тэгэхээр зэнэ тогтоолын 2 дахь заалт яг энэ хэлбэрээрээ байх нь хэр ойлгомжтой, утга агуулгатай зүйл байх юм бол гэж.

Тэгэхээр би бол тогтоолынхоо 1 дүгээр заалт дээр жоохон найруулгын өөрчлөлтүүд авмаар санагдаад байна гэж. Дам дамаа тэр макро эдийн засгийн төлөв байдал болон төсвийн тусгай шаардлагыг баримтлахад нөлөөлөх талаар үнэлгээ хийж гээд байгаа юм. Үүнийг төсвийн тусгай шаардлагуудаа тогтвортой хангахад хэрхэн нөлөө үзүүлж байгаад нь үнэлгээ хийх тухай л асуудал байгаа юм байна гэж ингэж л ойлгоод байна л даа би бол.

2 дугаарт нэгэнтээ ингээд үнэлгээ хийгээд үзчихсэн юм бол дүгнэлтээ авч хэрэгжүүлэх арга хэмжээнийхээ саналтай 2025 оны 1 дүгээр улиралд Улсын Их Хуралд танилцуулах тухай л асуудал байх юм байна гэж ингэж ойлгоод байна л даа. Үүгээрээ 2 дахь заалт нь хангагдаж байгаа юм байна гэж. Авч хэрэгжүүлэх арга хэмжээний саналаа гэдэг нь үндсэндээ тийм нөхцөл байдалд байгаа юм бол тэр авч хэрэгжүүлэх арга хэмжээний саналаараа дамжиж орж ирэх юм л гэж ингэж харж байна. Тэгэхээр энэ дээр ер нь ямар одоо бодол саналууд байна вэ. Ер нь бол Их Хурал өөрөө төсөв 2 сарын өмнө баталчхаад, 2 сарын дараа үүнд өөрчлөлт оруулах юм гэдэг санаа оруулж ирж болохгүй л дээ. Би бол энэ талаас нь л асуугаад ийм санал байна гэж.

Ц.Даваасүрэн: Гол нөгөө тодотголыг хийгээд байгаа санал бол бас энэ зардал өссөнтэй холбогдуулж мэдэгдэл хийгээд байгаа нөхдүүдийн тавьсан шаардлага юм байна лээ. Энэ

тодотгол хийе гээд. Тийм учраас тийм нэг зөрчил үүсэж болзошгүй юм. Зүгээр тэр эхний 1 дүгээр заалт найруулгын чанартай өөрчлөлт хийхэд бол хэдүүлээ ярилцаад шийдчихэж болно шүү дээ. Та саналаа оруулаад. Би бол зүгээр тэр шаардлагыг тогтвортой хангахад гээд юу гэсэн бэ. Тэгэхээр найруулгын хувьд болохгүй байна. Та юу ч гэсэн найруулаадах даа. Хэдүүлээ харъя. Тэгээд санал хураалгачихъя. Ганхуяг гишүүн.

Х.Ганхуяг: Ийм тогтоол батлах юм бол энэ төр үйл ажиллагаа явуулах ямар ч боломжгүй болно шүү дээ. 1 дүгээр улиралд багтаагаад тодотголоо өргөн барья гэхээр, 1 дүгээр улиралд ямар ч үйл ажиллагаа явуулах боломжгүй болно гэсэн үг. Хөрөнгө оруулалтын ажлууд явахгүй гэсэн үг. Тэгээд 1 дүгээр улирал ... үгүй үгүй, 1 дүгээр улиралдаа багтааж тендер зарладаг шүү дээ. Тэгэхээр чинь ямар ч тендер зарлагдахгүй. Бүгдээрээ 2 дугаар улирал руу шилжинэ. Тэгээд нөгөөдөх чинь явсаар байгаад оны эцэс гэж шалгарч амжих юм уу, амжихгүй юм уу гэдэг л асуудал болно. 1 дүгээр асуудал.

2 дугаар асуудал төсвийг өнөөдөр батлах гэж байгаа юм бол тодотголыг 2 сарын дараа хийнэ гэдэг нь өөрөө утгагүй. Үүний оронд миний бодлоор бол энэ төсвийг ер нь буцаасан нь зөв гэж бодож байна. Төсөл санаачлагчид тэгээд ондоо багтаагаад батлаад тэгээд он гарангуут энэ төр нь өөрөө юу хийхээ ядаж хийх ажил нь тодорхой болно шүү дээ. Ийм нэг хүн хуурч байгаа юм шиг ийм тогтоол цөмөөрөө тогтоол батлаад яах юм.

Тэр Засгийн газар нь өөрөө хариуцлагатай байх ёстой. Тэр шаардлагатай тэр хэмнэлтүүдээ хийгээд өргөн барих хэрэгтэй. Мөнгөний бодлогод нийцүүлнэ гэж байна. Мөнгөний бодлого бол инфляцын 6 хувь гээд орчихсон байгаа шүү дээ. Тэгэхээр чинь бол энэ бол нэлээн хэмжээний хэмнэлт хийж байж мөнгөний бодлогод

нийцүүлнэ гэсэн үг шүү дээ. Хөрөнгө оруулалт хийгдэхгүй гэсэн үг. Урсгал зарлал бол нэлээн танагдана гэсэн үг. Тэгэхээр энэ бол хэтэрхий ерөнхий эсвэл зүгээр нэг ард иргэдийг өнөөдөртөө нэг аргалъя гэсэн ийм л тогтоол болох нь байна. Нэгэнт өнөөдөр бид нар төсвөө батална энэ тэр гэж явж байгаа бол магадгүй энэ тогтоолыг ярих нь зөв байх л даа. Гэхдээ энэ бол зүгээр л нөгөө хүний нүд хурж байгаа л ийм тогтоол болох нь байна. Төрийн ямар ч хөрөнгө оруулалт хийгдэхгүй, ямар ч үйл ажиллагаа явахгүй, явсаар байгаад л 2 дугаар улирал бол бүгдээрээ шийдэгдэнэ. Тэгээд тэр дотроосоо юу нь хасагдах юм, юу нь хасагдахгүй юм мэдэхгүй. Тэгээд дараа жил бол үндсэндээ хөрөнгө оруулалтын ажил бол үндсэндээ бүгдээрээ л зогсоно гэсэн үг. Нэгэнт одоо хугацаа байна. Шаардлагатай бол бүгдээрээ өдөр шөнөгүй хамаагүй хуралдъя. Засгийн газар 1 дэх өдөр юм уу, 2 дахь өдөр гэхэд цаад талын хугацаанд нь төсвийн төслөө дахиад өргөн барь гэдэг л ийм байдлаар л явах нь зөв болов уу гэж харж байна. Баярлалаа.

Ц.Даваасүрэн: Буцаах асуудал болохоор нөгөө дэгийнхээ тухай хуулиар явахаар энэ төсөв чинь тусгай дэгээр явдаг. Буцаах асуудал нь эхний нөгөө үзэл баримтлалын хувьд буцаах уу гэдэг дээр бид нар буцаахгүй гээд Их Хурал шийдчихсэн байгаа байхгүй юу. Тийм учраас нөгөө буцаах үндэслэлийг байхгүй болгоод хаячихсан байгаа юм. Тэгэхээр харин эхний хэлэлцүүлэг дээр бид нар шийдэх ёстой байсан байгаа байхгүй юу. Одоо энэ бол зардал нь болохгүй байна гэдэг ч юм уу. Ингээд Төсвийн тогтвортой байдлын хууль бусад шаардлагад нийцэхгүй байна гээд буцаах тэр зохицуулалт маань эхний хэлэлцүүлэг дээр хэлэлцэх эсэхийг дэмжье гэдэг дээр шийдэгдэх ёстой байсныг аваачаад өөрсдөө дэмжээд ингээд Их Хурлын асуудал болгочихсон.

2 дугаарт тэр бас ингээд 1 дүгээр улиралд багтаан тодотгол хийнэ гэдэг

чинь бас л явдалтай эд шүү дээ. Тийм учраас зүгээр яах вэ энэ асуудлыг нөгөө зардалтай холбогдуулж асуудал тавиад байгаа гишүүд л шаардаад байгаа юм байна лээ л дээ. Одоо 3 их наядыг бууруулъя гээд байгаа гишүүд байгаад байгаа шүү дээ. Тэд нар чинь л гарын үсэг зуруулаад л тэгээд ийм зүйлийг, тодотголыг 1 дүгээр улиралд багтааж хий гэсэн ийм л юм яриад байгаа юм байна лээ. Дамдинням, Ганбаатар гишүүн 2-ыг оруулчихъя.

Г.Дамдинням: Гишүүдэд өглөөний мэнд хүргэе. Төсвийн дагах Улсын Их Хурлын тогтоол орж ирж байна. Зүгээр энэ дээр одоо байгаа нөхцөл байдал юун дээр байгаа вэ гэхээр яах вэ 2 асуудал байгаад байгаа юм. 1 дүгээрт төсвийн урсгал зардлыг бууруулъя. Тэгээд бас энэ хуульд нийцэхгүй байгаа зардлуудыг бууруулъя. Халамжийн чинь чанартай зардлууд бас нэмэгдэж байгаад шүүмжлэлтэй хандаж байгаа гишүүдийн асуудал байгаа. Олны анхаарлын төвд байна. Зүгээр яах вэ хэдүүлээ хуулиа хараад явах ёстой. Хуулийн ямар ч гарцгүй мухардал руу чихээд бид нарт ямар ч үр дүн гарахгүй. Тэгээд одоо төсвийн 3 дугаар хэлэлцүүлэг явагдаж байна гэдэг чинь үндсэндээ батлагдах руугаа дөхөж байгаа байхгүй юу. Болчихож байна л гэсэн үг. Өөр өөрчлөлт орохгүй. Тэгэхээр хуулийн хувьд ерөөсөө 2 л гарц байгаа.

1 дүгээрт тодотгол хийх, 2 дугаарт Монгол Улсын Ерөнхийлөгч хориг тавих. Энэ үед бид нар дахиж ярих боломжтой болно. Тэгэхээр хэрвээ Их Хурал өөрөө энэ тодотголыг дахиж хийлгэх асуудал яригдах гэж байгаа бол одоо энэ 3 дугаар хэлэлцүүлгийг нь батлахдаа бид нар энэ тогтоолын төслөө давхар батлах ёстой. Тогтолын төслөө давхар батлахад хугацаан дээр харин яримаар байгаа юм. Энэ 2 дугаар зүйл байгаад байгаа байхгүй юу. Төсвийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1-д заасны дагуу төсвийн тодотголын төслийг 2025 оны 1 дүгээр улиралд

багтаан Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх гэдэг. Энэ бол яг л үнэн л дээ. Ирэх оны эхний 3 сар ямар ч худалдан авах ажиллагаа явагдахгүй. Ирэх жил компаниуд төрөөс ажил авч хийдэг компаниуд ямар ч ажилд орохгүй. Ирэх жил төр өөрөө үйл ажиллагаагаа явуулахад бүтэн ¼-ийг нь алдана л гэсэн үг. Тэгэхээр би бол энэ төсвийн тодотголыг хэрвээ хийлгэх гээд байгаа бол өнөөдөр хэдүүлээ буцах араагүй болчихсон байгаа яг энэ хуулийнхаа дагуу энэ төсвийг нь баталж гаргаад л, маргааш нь ирэх 7 хоногт өөрөөр хэлбэл 12 дугаар сарын 1-ээс өмнө төсвийн тодотголыг өргөн бариулаад дахиад ярьчихъя. Нэгэнт тодотгол ярих гээд байгаа бол он давуулж ерөөсөө болохгүй байхгүй юу. Он давуулж ерөөсөө болохгүй. Төрийн ажил хойшоо явна. Тэгэхээр оноос өмнө бид нарт дараагийн төсвийн жил эхлэхээс өмнө бид нарт бараг 2 сар гаруй хугацаа байна шүү дээ. Эндээ багтаагаад амжуулчихъя л гэдэг ийм л саналтай байна. Тэгэхээр хугацааг нь бол жоохон наашилуулъя гэсэн ийм л хүсэлт байна.

Ц.Даваасүрэн: Хэрвээ саналаа зарчмын зөрүүтэй саналаар хураалгахаар бол бичиж өгнө шүү. Ганбаатар гишүүн.

Г.Ганбаатар: 2025 оны төсөв чинь нэлээн хэл ам, хэрүүл иуугиантай батлагдах юм шиг байна. Одоо энэ тэртээ тэргүй ингээд 3 дугаар хэлэлцүүлгээ батлах нь дээ. Зарим нэг нөхдүүд хуулийн дэг тэртээ тэргүй буцаахгүй болсныг мэдээд зарим нэг нь жоохон улс төр хийчих шиг боллоо. Тэгээд энэ тогтоолын төсөлтэй холбоотой санал дээр бол түрүүн нэг нь болох дээр дөнгөж 12 дугаар сардаа яаралтай эргээд төсвийн тодотголоо хий гэж байх шиг байна. 1 дүгээр улиралдаа багтаагаад үнэлгээ хийе гэсэн ийм тогтоолын төсөл орж ирэх юм байна. Угаасаа бол уурхай, эрдэс баялгийн үнэ ч унаж байна. Дээрээс нь угаасаа бид 2 дугаар улиралдаа бараг

тодотгол хийж таарах байх даа. Тэгээд хэрвээ юу байгаа бол 2025 оныхоо 2 дугаар улиралдаа багтаан Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх гээд бараг оруулчихсан нь дээр болов уу гэсэн тогтоолын төслийн 2 дээр тийм төсвийн тухай хуулийн 34.1-д заасны дагуу гэдгийгээ 2 дугаар улирал болгоод найруулчихвал яасан юм бэ гэсэн нэг ийм л санал байна даа.

Ц.Даваасүрэн: Аубакир гишүүн.

Т.Аубакир: Баярлалаа. Улсын төсвийг бол анхнаас нь, өргөн барихаас нь хойш дэмжээд явж байгаа. Сая Ганбаатар гишүүн бас хэлж байна. Зарим нэг хүмүүс улс төр хийгээд ч байгаа юм шиг. Улсын төсвийг батлах онцгой бүрэн эрх бол Улсын Их Хуралд байгаа. Сая Ганхуяг гишүүний хэлдгээр хойш нь тавихгүйгээр ондоо багтаагаад тодотголоо хийхээр энэ тогтоолын төслөө оруулж ирэх нь зөв байх. Яагаад гэхээр ирэх жилийн бизнес эрхлэгчид, ард иргэдийн ахуй амьдрал энэ улс эх орны бүх л хувь заяатай холбоотой ийм чухал үйл явдал шүү дээ. Тийм учраас энэ тогтоолын төслөө ондоо багтаагаад өргөн барихаар өөрчилж оруулж ирэх нь зөв байх гэж бодож байна. Төсвөө бид нар ямар ч тохиолдолд дэмжээд, батлаад явахгүй бол болохгүй. Ямар ч нөхцөлд. Тийм учраас энэ тогтоолын төсөл дээрээ хэдүүлээ оноос өмнө тодотголоо хийх нь зөв гэсэн байдалтайгаар оруулж ирэхийг хүсэж байна. Баярлалаа.

Ц.Даваасүрэн: Тэгээд энэ 1 дүгээр улиралд багтаан тодотгол хийе. Энэ макро эдийн засгийн төлөв байдалд үнэлгээ хийе гээд байгаа энэ асуудал бол нөгөө зардал өслөө гээд байгаа гишүүдийн л асуудал юм байна лээ л дээ. Би тэгээд бас жоохон гайхаад байгаа юм. Үгүй ээ, тэр дотор миний өмнө Төсвийн байнгын хорооны дарга хийсэн хүн өөрөө явж байгаа шүү дээ. Би ажил аваад 4 сар л болж байна шүү дээ. 2021 онд 11 их наяд байсан төсөв өнгөрсөн 2

жилийн хугацаанд 27 болсон. Үгүй ээ, тэр үед тэгээд өөрсдөө энэ Байнгын хороог удирдаж байж яагаад энэ зардлыг өсгөсөн юм гэдэг асуудал байгаа байхгүй юу. Өөрөө Байнгын хорооны дарга ахалсан байсан мөртөө одоо болохоор тэрийгээ буцаагаад бууруулъя гээд байгаа нь бол ойлгомжгүй л байгаад байгаа юм л даа. Тэгэхээр энэ нөхдүүдийн л тавьсан тэр шаардлагаас болж л энэ тогтоолын төсөл боловсруулагдаж орж ирж байгаа юм байна лээ.

Ингээд хэрвээ энэ тогтоолын төсөлтэй холбогдуулаад зарчмын зөрүүтэй санал байвал хэдүүлээ тэр зарчмын зөрүүтэй саналаар хураагаад дэмжсэн, дэмжээгүйгээр нь найруулаад явчихъя.

Гишүүд асуулт асууж, үг хэлж дууслаа. Тогтоолын төсөлтэй холбоотой санал гаргасан гишүүд саналаа өгье. Эхнийх хэнийх байна.

Батжаргал гишүүний санал байна. Эхнийх нь болохоор “шаардлагыг” гэсний дараа “тогтвортой хангахад” гэдэг чинь нэг найруулгагүй л болчхоод байна даа. Тогтвортой байдалд юм болов уу. Тогтвортой хандахад, тогтвортой хандахад юм уу. Шаардлагыг тогтвортой хандахад гэхээр жоохон найруулга тийм биш үү. Макро эдийн засгийн төлөв байдалд болон төсвийн тусгай шаардлагыг тогтвортой баримтлахад гэж хэлбэл яадаг юм. Тэгээд тогтвортой баримтлахад хэрхэн нөлөөлөх талаар үнэлгээ хийх. Үгүй ээ, энэ чинь өөрөө бас энэ найруулга нь жоохон муу юм биш үү. Гишүүд ээ, ингэж найруулъя. Тусгай шаардлагыг тогтвортой хангахад нөлөөлж буй хүчин зүйлийн талаар үнэлгээ хийх. Тийм үү. Тогтвортой хангахад нөлөөлж буй хүчин зүйлүүдийн талаар.

Гишүүд ээ, эхний 1 дүгээр заалтад бол төсвийн тусгай шаардлагыг тогтвортой хангахад нөлөөлж буй хүчин зүйлүүдийн талаар үнэлгээ хийж, 2025

оны 1 дүгээр сард багтаан Улсын Их Хуралд танилцуулах гэж. Тогтвортой хангахад нөлөөлж буй хүчин зүйлүүдийн талаар гэсэн найруулга.

Батжаргал гишүүний гаргасан тогтоолын төслийн ... хөөе гишүүд ээ, Тогтоолын төслийн “2/Төсвийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1-д заасны дагуу төсвийн тодотголыг 2025 оны 1 дүгээр улиралд багтаан Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх” гэсэн заалтыг хасъя гэдэг санал гаргаж байгаа юм байна. Энэ саналыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Батжаргал гишүүн өөрөө мэдээж дэмжсэн байж таарна. 14 гишүүнээс 2 дэмжиж, энэ санал дэмжигдсэнгүй. Хасах санал дэмжигдсэнгүй.

Тэгвэл одоо хугацааны талаар санал хураалтууд явъя. Жавхлан сайдын микрофоныг өгье.

Б.Жавхлан: Баярлалаа. Би Байнгын хорооны гишүүн биш л дээ гэхдээ үг хэлэх боломж өгч байгаад баярлалаа. Ийм л юм байгаа юм. Засгийн газар энэ жил цоо шинэ цаглавраар буюу 9 сарын 1-нд төсвөө өргөн барьсан. Тэрнээс хойш ингээд 70 гаруй хонолоо. 10 сарын 1-ээс ажлын хэсэг байгуулагдаад, дэгийнхээ дагуу ингээд явсан. 2, 3 дугаар хэлэлцүүлэг хүртэл ингээд л амжилттай явсан. Өнөөдөр бид нар 3 дугаар хэлэлцүүлэгтээ ирчихсэн байна. Тэр үед 2 дугаар хэлэлцүүлгээс өмнө яригдах ёстой асуудлуудыг тавиад байгаад л бид нар гайхаад байгаа юм. Одоо энэ ч дүүрч. Цаашаагаа яах вэ гэдэг асуудал гарч ирж байгаа юм. Тэгэхээр тэр хугацааг 1 дүгээр улирал энэ тэр гэх юм бол Монгол улс төсөвгүй явна л гэсэн үг. 1 дүгээр улирал дуустал ямар ч баримжаа байхгүй, ямар ч луужин байхгүй. Ерөөсөө энэ эдийн засагт оролцогчид чинь хаашаа явахаа ч мэдэхгүй ийм л байдал үүсэх юм байгаа юм. Тэгэхээр зовлонгийн түргэн нь дээр. 1 өдрийн наана ч гэсэн энэ эдийн засаг нь өөрөө хаашаа явах вэ гэдэг нь тодорхой болж байвал аль алинд нь сайн,

аль алинд нь хэрэгтэй. Бид үүгээр ингэж хамаагүй бас улс төр хийж, хугацаа алдаж энэ улс орноо бүр их эвгүй байдалд, мухардалд оруулж ингэж болохгүй юм байгаа юм. Энэ томоохон төслүүдээ 14 мега төсөл, 14 томоохон реформ энэ бүгдийгээ хийж амжуулъя гээд Их Хурал 2 сарын өмнө мөрийн хөтөлбөрөө баталсан Засгийн газрын. Энийгээ хэрэгжүүлэхийн тулд байж болох хамгийн бага алдагдалтай ийм л төсөв оруулж ирсэн. Засгийн газар, Улсын Их Хурал төсвөө хэрхэн баталж бидэнд хүргүүлэх нь үү, энийг хүлээгээд л байж байгаа. Их Хуралд өргөн барьснаас хойш Засгийн газрын оролцоо бол хаагддаг. Улсын Их Хурал бүрэн эрх нь гагцхүү яг энд л оршиж байгаа. Ийм юм байгаа юм. Тэгэхээр Улсын Их Хурлын гишүүд маань Улсын Их Хурал маань энэ асуудлыг түргэн шуурхай шийдээд, нэг тийш нь болгоод, энэ эдийн засгийг энийг гацаагүй цааш нь голдиролд нь явуулна гэдэгт одоо итгэж байна.

Зардал бууруулна, алдагдал бууруулах ёстой гэдэгтэй бол Засгийн газар бүр 100 хувь нийлж байгаа юм. 100 хувь нийлж байна. Ийм чиглэл өгч байгаа бол бас сайн хэрэг. Гэхдээ бас бид томоохон мөрийн хөтөлбөр, томоохон зорилго тавьчихсан байгаа. Бид олон зүйлийг энд харах ёстой. Мэдээж мөнгөний бодлого, мөнгөний орчноо ч бас бид харах ёстой. Гадаад геополитик бүх юмаа л тохируулж бүх агрегатуудаа тохируулж явах ёстой. Ганцхан үзүүлэлтийг хараад бүгдийг нь намжаана гэвэл бид хөгжлөө хойш нь татаж магадгүй. Нөгөө зориод байгаа 1 хүнд ноогдох үндэсний орлого маань 10 мянган доллар хүрнэ гэдэг маань 1, 2 жилээр хойшлохыг үгүйсгэхгүй. Магадгүй 4, 5 жилээр хойшлохыг ч үгүйсгэхгүй. Тийм учраас энэ бүгдийг харж оруулж ирсэн ийм л төсөв юм байгаа юм.

Харин би нэг зүйл дээр одоо 100 хувь итгэлтэй байна. Энэ төсөв дотор хууль зөрчсөн, хуультай нийцэхгүй байгаа

1 төгрөгийн ч эдийн засгийн ангилал бүхий зардал байхгүй гэдгийг албан ёсоор хэлмээр байгаа юм.

Тийм учраас хууль юмнуудаа харж байгаад аль болох л түргэн нэг талд нь гаргаад, энэ улс орны эдийн засаг, төсвийг нь их тодорхой болгох нь зүйтэй гэсэн ийм санал хэлье. Баярлалаа.

Ц.Даваасүрэн: Батжаргал гишүүний санал дэмжигдээгүй учраас одоо Дамдинням гишүүний саналаар хураалгана. Төсвийн энэ дагаж гарах тогтоолын 2 дугаар заалттай холбогдуулаад “Төсвийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1-д заасны дагуу төсвийн тодотголыг 2024 оны 12 сард багтаан хийж Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх” гэж өөрчилье гэж байна. Дамдинням гишүүний гаргасан санал. Энэ саналыг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. 14-9 гишүүн дэмжиж, уг санал дэмжигдлээ.

Найруулга дээр бол Батжаргал гишүүний саналаар би хураалгачихъя.

1 дүгээр заалт дээр тусгай шаардлагыг тогтвортой хангахад нөлөөлж буй хүчин зүйлүүдийн талаар үнэлгээ хийж гэж өөрчлөн найруулъя. 1 дүгээр саналыг яриад байна шүү дээ. Өөрчлөн найруулалд орж байгаа юм. Зүгээр найруулга орж байгаа юм. Батжаргал гишүүний найруулгын саналыг дэмжье гэдгээр санал хураалт явуулъя. 14-5 гишүүн дэмжиж, энэ санал дэмжигдсэнгүй. Тэгээд өмнөхөөрөө үлдлээ.

Ингээд санал хураалт. Аубакирынх аль юм. Дамдиннямынх дэмжигдчихсэн шүү дээ Аубакирынхан адилхан юм байна. Байж байгаарай.

Одоо тогтоолоо хэдүүлээ батална шүү. Өөр санал байна уу. Энэ хэнийх юм. Ганбаатар гишүүнийх юм уу. Харин хураахгүй юм байна. Ийм байна. Ганбаатар гишүүний санал 2 дахь дэд

заалтын “1 дүгээр сард” гэснийг “2 дугаар улиралд” гэж өөрчлөх. Түрүүний нөгөө 12 сард гэдэг санал дэмжигдсэн учраас дэгээрээ хурааж болохгүй юм байна. Шаардлагагүй. Өөр санал байна уу. Байхгүй юу. Өөр гишүүдэд санал байна уу. Байхгүй. Санал алга байна.

Дараагийн батлах хэсэг рүүгээ орно хэдүүлээ. Байнгын хороогоор саяын дэмжигдсэн саналуудыг нэмж тусган, тогтоолын төслийн эцсийн хувилбарыг бэлтгэж чуулганы нэгдсэн хуралдаанд оруулна. Саяын байдлаар 12 сард багтааж гэдгээр орно.

“Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг анхны хэлэлцүүлгээр баталъя гэсэн горимын санал гаргаж байна.

Горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя. 14-9 гишүүн дэмжиж, 64,3%-аар анхны хэлэлцүүлгээр батлагдахаар дэмжигдлээ. Аубакир, Дамдинням гишүүн, Батлут 3 гишүүн дэмжсэн юм байна. Протоколд авлаа.

“Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Дамдинням гишүүн танилцуулъя.

Хэлэлцэх асуудал дууссан тул Төсвийн байнгын хорооны хурал хаасныг мэдэгдье. Баярлалаа гишүүд ээ.

10.26 цаг.

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ
БУУЛГАЖ, ХЯНАСАН:
ШИНЖЭЭЧ

Э.СУВД-ЭРДЭНЭ